



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Б корпус, Засгийн газрын IX байр,
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976-51) 26 00 62
Цахим шуудан: info@spa.gov.mn
Цахим хуудас: www.spa.gov.mn

2024.04.04 № А-1/1460
танай _____-ны № _____-т

Тодруулга хүргүүлэх тухай

Тус газраас зарласан БХБЯ/202401030062 дугаартай XII.4.2 “Шинэ-Хархорум” байр зүйн зураг зохиох, ортофото зураг үүсгэх /Архангай, Өвөрхангай/ төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс ажлын даалгаврын талаар тодруулга авах хүсэлт ирүүлсний дагуу захиалагчаас ирүүлсэн тодруулгын хариуг дараах байдлаар хүргүүлж байна.

Оролцогчоос ирүүлсэн дараах тодруулгад хариуг хүргүүлж байна. Үүнд:

1. Ажлын даалгаврын 3.2.1-д нийт талбай 189,363 га. Үүнээс эхний ээлжинд 92000 га, төлөвлөлтийн хугацаанд – 97,363 га гэж заасан, мөн хоёр хэсэг талбайн хил өгөгдсөн. Энэхүү хилийг нийт талбайгаар буюу 189,363 га эсхүл 97,363 га гэдгийг тодорхой болгоно уу.

- Ажлын даалгаврын төлөвлөлтийн хугацаа болох 97,363 га талбайд хийгдэх ажил.

2. Тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 2.1-д нийт төсөвт өртөг 3,718,000,000.0 төгрөг гэж заасан. Тооцоог бодсон төсвийн задаргааг өгнө үү.

- Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 123 дугаар тушаалаар баталсан “Геодези зураг зүйн ажлын жишиг үнэ” /БД 81-103-21/-ийн дагуу ажлын тоо хэмжээ, төсөвт өртгийг тооцсон.

3. Тендерийн баримт бичгийн 5 дугаар бүлэг. Тендерийн жишиг маягтад Маягт 8, Маягт 9 гэж байхгүй байна.

- Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/260 дугаар тушаалаар батлагдсан “Үйлчилгээ авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг-2024” жишиг баримт бичгийн дагуу боловсруулсан бөгөөд зүйл заалт бүр нь тусгагдсан орхигдуулсан зүйл үгүй болно.

Захиалагчаас ирүүлсэн тодруулгын хариуг хавсаргав.

ДАРГА



Ц.БАТЗУЛ

1324023910

ТХААГ-2024-А4



ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ

**ШИНЭ ХАРХОРУМ ХОТЫН
БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН
АСУУДАЛ ХАРИУЦСАН ЗАХИРГАА**

Далай тауэр, Юнескогийн гудамж, 1 дүгээр хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14220
Утас: 7771 1220, Цахим хуудас: www.kharkhorum.gov.mn


2024. 04. 03. № 02/104
танай _____-ны № _____-т

Хариу хүргүүлэх тухай

“Шинэ Хархорум” хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардагдах байр зүйн зураг зохиох эхний ээлжийн ажил 92000 га талбайн /Архангай, Өвөрхангай/ БХБЯ/202310021 дугаар зөвлөх үйлчилгээний тендерийг 2023 оны 11 дүгээр сарын 09-ний зарлаж гүйцэтгэгчийг шалгаруулан гэрээ байгуулсан.

Иймд 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдөр зарласан БХБЯ/20240103062 дугаар “Шинэ Хархорум” хотын байрзүйн зураг зохиох, ортофото зураг үүсгэх тендер нь ажлын даалгаврын төлөвлөлтийн хугацаа болох 97363 га талбайд хийгдэх ажил бөгөөд Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 123 дугаар тушаалаар баталсан “Геодези зураг зүйн ажлын жишиг үнэ” /БД 81-103-21/-ийн дагуу ажлын тоо хэмжээ, төсөвт өртгийг тооцсон болно.

ДАРГА



Н.НАЦАГДОРЖ

142420182

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

Д/д	Үндэслэл	Ажлын нэр төрөл	Хэмжих нэгж	Ажлын хэмжээ
1	1	2	3	4
2	155	1:2000-ны масштабын байр зүйн зураглалын ажил	га	97,363
3	190	Газар доорх инженерийн шугам сүлжээний худгийн хайгуул, судалгаа	худаг	10
4	193	Газар доорх инженерийн шугам сүлжээний шугамын судалгаа, эргэлт тодорхойлох	цэг	10
5	66	Нисэх онгоцоор агаараас зураг авах фотограмметрийн төсөл зохиох	кв.км	1893.63
6	70	Агаар мандлаас газрын зураг авах ажил. Агаарын зургийн орон зайн шийд (GSD) 5 см	кв.км	1893.63
7	97	Аэротриангуляцийн тэгшитгэн бодолт ба зургийн гадаад чиглүүлгийн элементийг нарийвчлан тодорхойлох	зураг	16907
8	102	Өндрийн (DEM) болон газрын гадаргын (DTM) тоон загвар үүсгэх, засварлах. Торлолын алхам /grid interval/ 20 см	кв.км	1893.63
9	126	Нисэх онгоц, эсвэл нисэгчгүй нисэх төхөөрөмжөөр авсан зурганд орто засвар хийх, ортофото зүймэл зураг үүсгэх. (GSD=10 см)	кв.км	1893.63
10	249	Зураглалын ажлын тайлан бичилт	трапец	842
11		Ажлын талбайд ирж очих	км	954
12	е.х.16	Тээврийн зардал	км	
13		1-16-ын дүн (А)		
14		Норм норматив боловсруулах сангийн шимтгэл (В)		
15		Магадлашгүй ажлын зардал (С)		
16		Хяналт шалгалт (D)		
17		A+B+C+D		
18		НӨАТ (E)		
19		Нийт төсөв		

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН 2021 ОНЫ 123 ДУГААР
ТУШААЛААР БАТАЛСАН "ГЕОДЕЗИ ЗУРАГ ЗҮЙН АЖЛЫН ЖИШИГ ҮНЭ"
/БД 81-103-21/-ИЙН ДАГУУ ТООЦОХ